

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн  
20 ... оны ... дүгээр сарын ... өдрийн  
... дугаар албан бичгийн хавсралт ...

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	№	Арга хэмжээ /салбар зөвлөлийн чиг үүрэг/	Ажил үйлчилгээ	Биелэлт
<b>Нэг. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, гүйцэтгэлийн удирдлага</b>				
1	1.  2.	1.1. Яам болон харъяа агентлагийн хэмжээнд төрийн албаны шинэтгэл, боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэшлийн зөвлөлгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх	1.1.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албаны стандарт, боловсон хүчний бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн хөдөлгөөн бүрэлдэхүүнд үнэлэлт дүгнэлт өгөх	- УУХҮЯ-ны дэргэдэх ТАЗСЗ нь Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, 2018 оны жилийн эцсийн байдлаар яамны хэмжээнд түр орлон гүйцэтгэгчгүй, хөлсөөр ажиллах гэрээт ажилтангүй, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөөгүй албан хаагчгүй буюу 100 хувь төрийн жинхэнэ албан хаагчаар боловсон хүчин хүний нөөцийг бүрдүүлэн ажиллав. - УУХҮЯ шинэчилсэн бүтцээр 78 орон тоотой батлагдсан бөгөөд Төрийн өндөр албан тушаалтан 2, Ажлын албаны 4, Төрийн захиргааны 69, Төрийн үйлчилгээний 3 албан тушаалтан ажиллаж байна. Биелэлт 100%
1	3.		1.1.2. Яамны төрийн албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлт, баяжилтад тусгайлсан үзлэг шалгалт хийж, шинэчилсэн судалгаа, нэгдсэн мэдээлэлтэй мэргэшил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх	- Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 265/72 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий Төв комиссын ажлын хэсэг 2018 оны 11 дүгээр сарын 11-16-ны өдрүүдэд тус яаман дээр ажилласан. Уг шалгалтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд төрийн албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлт, баяжилтад урьдчилсан үзлэг шалгалт хийж, төрийн албан хаагчийн анкетыг шинэчлүүлж, шаардлагатай бусад бичиг баримтыг нэмж бүрдүүлэх ажлыг зохион байгуулав. Биелэлт 100%

2 4.		<p>1.1.3. Ашигт малтмал, газрын тосны газарт Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албаны стандарт, боловсон хүчний бодлогын хэрэгжилт, төрийн албан хаагчийн хөдөлгөөн бүрэлдэхүүнд үнэлэлт дүгнэлт өгөх</p>	<p>Ашигт малтмал, газрын тосны газарт Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албаны стандарт, боловсон хүчний бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан 6 хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ТАЗСЗ-ийн дүгнэлт, тогтоол гаргуулан, 5 нэр дэвшигчийг тус тусын нэр дэвшсэн албан тушаалд томилуулав. Хүнд үйлдвэр, техник технологийн хэлтсийн даргад нэр дэвшигч удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцээгүй, түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.</p> <p>- Тус агентлаг нь 2018 оны жилийн эцсийн байдлаар батлагдсан 185 орон тоон дээр төрийн захиргааны 123, төрийн үйлчилгээний 45, гэрээгээр хөдөө орон нутаг дахь төлөөлөгчид ажиллаж байна.</p> <p>Биелэлт 90%</p>
3 5.		<p>1.1.4. Агентлагийн төрийн албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлт, баяжилтад тусгайлсан үзлэг шалгалт хийж, шинэчилсэн судалгаа, нэгдсэн мэдээлэлтэй мэргэшил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх</p>	<p>Улсын хэмжээнд зохион байгуулагдсан төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үзлэг шалгалтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, баяжилт, судалгаа, нэгдсэн мэдээлэлтэй болох тал дээр мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэв.</p> <p>Биелэлт 100%</p>
4 6.		<p>1.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежер болон төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажилд мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх</p>	<p>Үр дүнгийн гэрээ, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнд төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажилд тусалж, мэдээллээр ханган ажиллав.</p> <p>Биелэлт 100%</p>
7.		<p>1.1.6. Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, Ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн хэрэгжилтийг шалгаж, арга зүйн зөвлөмж өгнө.</p>	<p>- ТНБД-ын 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар “УУХҮЯ-ны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан, байгууллагын үндсэн зорилт, чиг үүргүүд нь газар, хэлтсийн чиг үүргүүдэд, нэгжийн чиг үүргүүд нь албан тушаалд бүрэн хуваарилагдсан эсэх, орхигдсон, давхардсан чиг үүрэг байгаа</p>

			эсэхийг шинжиллээ. Ажлын хэсэг салбарын стратеги төлөвлөлт, бодлого, ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийсний дагуу дүгнэлт гарган, шинэчилсэн хөтөлбөр боловсруулан Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг батлууллаа. Биелэлт 100%
8.		1.1.7. Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, Ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн хэрэгжилтийг шалгаж, арга зүйн зөвлөмж өгнө.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрыг 12 хэлтэс, нэгж, орон тооны дээд хязгаарыг 185 байхаар баталсан. Ажлын байрны тодорхойлолт, тушаал шийдвэрийн хэрэгжилттэй 2018 оны 10 дугаар сард төлөвлөсний дагуу танилцаж, зөвлөгөө өгсөн. Биелэлт 100%
9.		1.1.8. Яам болон агентлагийн Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, ёс зүйн хороодын ажилтай танилцах мэргэжил, арга зүйгээр хангах	ТАЗСЗ Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газартай хамтран 2018 оны 9 дүгээр сард Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай танилцан, ТАЗСЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 18/16 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий УУХҮЯ-ны “Ёс зүйн хороо”-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа. Тайлангийн хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм зөрчиж арга хэмжээ авагдсан 1 албан хаагч байна. /Биелэлт 100%/
<b>Хоёр. Төрийн албаны хүний нөөцийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт</b>			
5	10.	2.1.Төрийн албаны хүний нөөцийн хөгжлийн бодлого төлөвлөлт, сургалт, судалгаа шинжилгээ, хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах	2.1.1. Хүний нөөцийн хөгжлийн бодлогын хүрээнд ажиллагсдын сургалтын хэрэгцээ, салбарт шаардлагатай мэргэжлийн судалгааг гаргаж, яам, агентлагийн ажиллагсдын сургалтын мастер төлөвлөгөө боловсруулахад зөвлөх, дэмжлэг үзүүлэх
			УУХҮЯ-ны харъяа Ашигт малтмал, газрын тосны газар нь Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнд салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тусгай заалтыг батлуулдаг бөгөөд, гэрээний дагуу сургалтын дансанд хөрөнгө төвлөрүүлж, жил бүр сургалтын зардлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ТНБД-аар батлуулан, төлөвлөсний дагуу зарцуулдаг. 2018 оны салбарын сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгч, хамтран ажиллан, ТНБД-ын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаалаар сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлуулав. Биелэлт 100%
6	11.		2.1.2. “УУХҮЯ-ны албан хаагчдын
			Дээр батлагдсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан

		<p>2018 оны сургалтын төлөвлөгөө"-ний биелэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хангуулахад туслалцаа үзүүлэх</p>	<p>"УУХҮЯ-ны албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу 2018 онд төлөвлөсөн 24 сургалтаас 23-ыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бодлогын газрууд тус тусын чиглэлээр 4 сургалтыг хариуцан зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- 2 төрийн албан хаагчид магистрын сургалтын төлбөр олгоход дэмжлэг үзүүлэв.</li> <li>- Удирдлагын академийн Төрийн захиргааны удирдлагын мэргэшүүлэх сургалтанд 2 албан хаагч хамрагдаж байна.</li> <li>- 2018-2019 оны хичээлийн жилд МУИС, ШУТИС болон бусад их дээд сургуульд магистрын сургалтад 6 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд ТНБД-ын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Чөлөө олгох тухай Б/126 дугаар тушаалаар тэдэнд хичээлийн жилийн хугацаанд ажлын 15-48 өдрийн цалинтай чөлөө олгож, сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэв.</li> <li>- 7 хоног бүрийн Баасан гаригт 09.00-10.00 цагийн хооронд мэдээллийн цагийг тогтмол ажиллуулж, сонирхолтой хичээл сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөхөд туслалцаа, дэмжлэг үзүүлж байна.</li> </ul> <p>Биелэлт 100%</p>
12.		<p>2.1.4 АМГТГ-ын Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг хангахад арга зүйн зөвлөгөө өгнө.</p>	<p>"2017-2020 онд хэрэгжүүлэх салбарын төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр"-ийн дагуу АМГТГ 2018 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагаа хэрхэн явуулах, сургалтанд хамрагдсан ажиллагсдын бүртгэлийг хөтлөх аргачлал болон нийт албан хаагчдыг сургалтанд жигд хамруулах талаар чиглэл өгөн ажиллаж байна. Үүний дагуу төлөвлөгөө, мэдээ тайланг хугацаандаа ирүүлсэн.</p> <p>Биелэлт 100%</p>
13.		<p>2.1.5. Хүүхдийн хөгжил, хүүхдийн эрхийг хамгаалах бодлого салбарын хуулинд тусгуулах тал дээр санаачлагатай ажиллах</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. ТЗУГ 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Хүүхдийн эрх, хамгаалал" сэдвээр яамны ажилтан, албан хаагчдын дунд сургалтыг зохион байгуулав.</li> <li>2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгууллагын эцэг эхийн зөвлөлийн төлөөлөлд зориулсан "Хүүхдийн хүмүүжлийн уламжлал шинэчлэл", "Хүүхдийн хөгжил, чөлөөт цаг", "Хүүхэд хамгааллын бодлого, Эцэг эхийн зөвлөл" сэдэвт бүтэн өдрийн сургалт семинарт тус яамнаас 3 төлөөлөл оролцон батламж авсан.</li> <li>3. Байгууллагын ажилтан, албан хаагчид, эцэг эх иргэн хүн,</li> </ol>

			<p>хүүхдийн эрхийг ойлгох, үүргийг таниулах, хүлээн зөвшөөрөх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалахын тулд “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулахаар тушаалын төсөл, уг зөвлөлийн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулаад байна. Мөн тус яамны ажилтан, албан хаагчдад зориулан “Хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/218 дугаар тушаалаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалттайгаар хэрэгжүүлэх салбар дундын байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулагдан тус яамны УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадорж, Төрийн захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Я.Бадрах нар ажиллан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/027, А/047, А/35 дугаарын хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан.</p> <p>Биелэлт 100 %</p>
14.		<p>2.1.6. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мөрдөх хүүхэд хамгааллын журам” боловсруулан мөрдөх үйл ажиллагаатай холбоотой яамны эцэг эхийн зөвлөл байгуулахад оролцох зөвлөгөө өгүүлэх, хэрэгжилтэнд манлайлан оролцох</p>	<p>1. Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор салбарын сайдын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах” чиглэл өгөх тухай албан бичиг 2018 оны 11 дүгээр сард, албан даалгавар 2018 оны 12 дугаар сард тус тус гарч, орон нутгийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-дад хүргүүлэв. Салбарын сайдын чиглэл болон албан даалгаварт:</p> <p>1 дүгээр заалтанд: “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д заасан ажилд насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахгүй байх;</p> <p>4 дүгээр заалтанд: Хөдөлмөрийн аюултай нөхцөлд хүүхдийг ажиллуулсан, бичил уурхайд хөдөлмөр эрхлүүлсэн ААН-үүдийн мэдээллийг бүртгэн холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;</p> <p>5 дугаар заалтанд: Бичил уурхайгаар ашигт малтмал</p>

			<p>олборлохыг хүссэн иргэд, ААНБ-уудаас тухайн нутгийн Засаг даргатай хийх гэрээнд хүүхдийн хөдөлмөрийг үл тэвчих заалтыг тусгах, зөрчсөн этгээдтэй гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах;</p> <p>6 дугаар заалтанд: Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд анхаарч бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн иргэд, ААНБ-уудад тусгай зөвшөөрөл олгох журамд“Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаартусгасан.</p> <p>2. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад салбарын сайдаас “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах” чиглэл болон албан даалгавар 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/3082 тоот албан бичиг, салбарын сайдын Хүний эрх, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот албан даалгавар тус тус гарч салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд, аймгуудын Засаг дарга нар холбогдох газар нэгж, агентлагт хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Биелэлт 100%</p>
15.	2.2. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2.2.1. “УУХҮЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хангуулахад туслалцаа үзүүлэх	<p>“УУХҮЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг ТНБД-ын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/32 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөнд 19 ажил төлөвлөснөөс 18 ажил хэрэгжсэн байна. Төсөв, санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажил хэрэгжээгүй тул Ажиллагсдын эрүүл мэндийн боловсрол дзориулан 2 удаагийн сургалт мэдээлэл хийж, ажлын цагийг хэмнэх, тавтхтай үйлчилгээ авах зорилгоор ажлын байранд ээрт одорхойт өрлүүдээр /цусны дэлгэрэнгүй, сахарын, Д-витамины зэрэг/ шинжилгээ авч, хүннэг бүрт тусгайлан шинжилгээний хариуг хүргэж, зөвлөгөө өгөх, дахин шинжилгээнд харуулах зэрэг ажлуудыг хийлээ.</p> <p>- Төлөвлөгөөний дагуу:</p>

			<ul style="list-style-type: none"> <li>- Цасны баяр, яамны спортын уралдаан тэмцээн, явган аялал-зугаалга зохион байгуулж, ажиллагсдыг биен тамир спортоор хичээллэх боломжоор ханган спорт заал түрээслэн ажиллаж байна.</li> <li>- Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажиллагсдад тусламж, дэмжлэг үзүүлэх 18, гадаадад сургалтад хамруулах 2, хүүхэд асрах болон цалинтай цалингүй чөлөө олгох 31, нийт албан хаагчдын цалингийн шатлал зэрэглэл ахиулах болон зарим ажилтны цалинтай холбоотой 3 тушаал тус тус гаргаж, өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн байна.</li> <li>- 2018 оны сургалтын төлөвлөгөөний дагуу: <ul style="list-style-type: none"> <li>- Салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг 2018 оны сургалтын сонгон шалгаруулалтаар тус яамны 2, Ашигт малтмал, газрын тосны газрын 2 төрийн албан хаагчид гадаадад магистрт тэтгэлэгтэй суралцах эрх олгов.</li> <li>- Мөн тус яамны 2 төрийн албан хаагчийн магистрын сургалтын төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлсэн.</li> <li>- 7 хоног бүрийн Баасангаригт 09.00-10.00 цагийн хооронд мэдээллийн цагийг тогтмолажиллуулж, сонирхолтой хичээл сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөхөд туслалцаа, дэмжлэг үзүүлж байна.</li> </ul> </li> <li>Ажиллагсдынажиллах нөхцөл бололцоог сайжруулахын тулд бүх компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах төсвийг 2019 оны төсөвт суулгасан.</li> </ul> <p>Биелэлт 100%</p>
16.	2.2.2. АМГТГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөө"-ний биелэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хангуулахад туслалцаа үзүүлэх	ТАЗСЗ Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газартай хамтран 2018 оны 3 дугаар улиралд АМГТГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөө"-ний биелэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хангуулахад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулав. АМГТГ албан хаагчдынхаа нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөндөө 22 ажил төлөвлөснөөс 21 ажлыг хэрэгжүүлж, 95,4 % биелэлттэй ажилласан.	
17.	2.2.3. Яамны төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах хэрэгцээг судалж, 2019 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж,	Яамны төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах хэрэгцээг судалж, 2019 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж байна. АМГТГ-тай хамтран сургалтын зардлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан 2019 оны 1 дүгээр сард	

		мэргэшүүлэх болон давтан сургах зардлын тодорхой хувийг нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулан батлуулах арга хэмжээ авах.	багтаан батлуулна. Яамны албан хаагчдыг мэргэшүүлэх болон давтан сургах зардлын тодорхой хувийг нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулахаар боловсруулав. Биелэлт 95%
18.		2.2.4. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудаас олгодог сургалтын урамшуулын хөрөнгийн зарцуулалтын нэгдсэн төлөвлөгөөг батлуулахад зөвлөх, Агентлагийн албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөөг батлуулахад дэмжлэг үзүүлэх.	УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаалаар “Ашигт малтмал, газрын тосны газрын сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2018 оны төлөвлөгөө”-г батлуулав. Нэгдсэн төлөвлөгөөнд яамны албан хаагчдын мэргэшүүлэх сургалтад хамруулах зардлын тодорхой хувийг суулган батлуулав. /Хэрэгжилт 100 хувь/
19.		2.2.5.Төрийн албаны зөвлөлд яамны төрийн албан хаагчдын 2018 онд сургалтанд хамрагдсан бүртгэлийг хүргүүлэх, тайлагнах.	УУХҮЯ-ны 2018 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдсан ажиллагсдын бүртгэлийг хөтлөн нийт албан хаагчдыг сургалтанд жигд хамруулж байна. 2018 онд яамнаас гадаадад 15, дотоодод 58 албан хаагч /давхардсан тоогоор/ богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байна. Засгийн газрын худалдан авах ажиллагааны А-3 сургалтад 5 албан хаагч, - Гадаад хэлний сургалтын төвд англи хэлний сургалтад 5 албан хаагч, - Уртхугацааныбуюумагистрийнсургалтандгадаадад2дотоодод6, - Удирдлагынакадемийнмастерийнсургалтад 2 албанхаагчтустуссуралцажбайна. - МөнКанадулсын СЕСМИМ төсөлтэйхамтранзохионбайгуулжбуйуулуурхайнчиглэлийн 1.5 жилийнхугацаатайцахимсургалтадсалбарыннийт 12 иргэнсуралцажбайгаабөгөөдтусяамнаас 2 мэргэжилтэнхамрагдажбайна. -АТГ-аасзохионбайгуулжбуйавлигынэсрэгсургалтаднийт 69 албанхаагчхамрагдсан. Биелэлт 100%
<b>Гурав. Төрийн захиргааны удирдлага, мэдээллийн тогтолцоо</b>			
7 20.	3.1. Яам, агентлагийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдох мэдээ, тайлан, судалгааг Төрийн албаны	3.3.1. Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн мэдээллийн системд тухай бүр оруулж байх, энэ талаар харьяа агентлагуудад арга зүйн зөвлөмж өгч	Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг бүтэн жилээр, үйл ажиллагааны тайланг 2017 оны жилийн эцсийн байдлаар гарган 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 03/01 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. АМГТГ-ын хүний нөөцийн мэргэжилтнүүдтэй өдөр тутмын холбоотой ажиллаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,

		зөвлөлөөс баталсан нэгдсэн графикайн дагуу	ажиллана.	харилцан туслалцан ажиллаж байна. Биелсэн 100%
	21.	“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.4, 2.4.5-д заасан харьяаллаар гарган нэгтгэж Төрийн албаны зөвлөлд хүргүүлж байх.	3.3.2. 2018 оны Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан хүлээж авах хуваарь гаргаж харьяа агентлагт хүргүүлнэ.	Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг төрийн албан хаагчдын хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт мэдээллийг оруулж, мэдээллийн сантай болсон.Биелсэн 100%
	22.		3.3.3. Тухайн жилийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан ирүүлсэн дүн, түүнд гарсан зөрчил, анхаарах асуудлаар харьяа агентлагт мэдээлэл зөвлөгөө өгөх	Төрийн албан хаагчийн 2017 оны хөдөлгөөн, бүрэлдэхүүний тайланг 2018 оны 1 дүгээр сард ТАЗ-д хүргүүлсэн бөгөөд тайлангийн талаар зөрчил дутагдал гараагүй тул харьяа агентлагт мэдээлэл зөвлөгөө өгөх шаардлага гараагүй. Биелэлт 100%
8	23.	3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежер болон төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, төрийн	3.2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах Ажлын хэсгийг байгуулах, гэрээний төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулна.	Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежертэй “Үр дүнгийн гэрээ” байгуулсан. Яамны нийт 68 төрийн захиргааны албан хаагч Үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж, хагас жилээр 68, жилийн эцсийн байдлаар 65 төрийн захиргааны албан хаагч ҮДГ-ний биелэлтийг тайлагнав. /Биелсэн 100% /
	24.	жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлын мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах	3.2.2.Төсвийн шууд захирагч менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг үндэслэн Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулан хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөгөө өгнө.	Төсвийн шууд захирагчийн гэрээний салшгүй хэсэг болох яамны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу газар, хэлтсийн даргын үр дүнгийн гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллав. Биелсэн 100%
	25.		3.2.3. Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежер, Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгнө.	ХШҮДАГ УУХҮЯ-ны төрийн захиргааны албан хаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээний хагас жилийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгөн ажиллав. Биелэлт 100%
9	26.	3.3. Төрийн албаны зөвлөлийн “Цахим хуудас”, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудас”-аар салбар зөвлөлийн үйл ажиллагааг, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэн сурталчлах, холбогдох	3.3.1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны тойм, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын мэдээллийг яам, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд тухай бүр байршуулна.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 2018 онд 7 удаа хуралдаж, хурлын тэмдэглэл 7, Төрийн албаны зөвлөлд болон бусад газарт 18 албан бичиг, комисс байгуулах тухай 6 тогтоол, нэр дэвшүүлэх тухай 7, ёс зүйн хороог шинэчлэн байгуулах 1, нийт 14 тогтоол гаргасан байна. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт буюу албан тушаалд томилсон тушаал, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын мэдээллийг яам, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд тухай бүр байршуулж байна. Биелэлт 100%

27.	<p>мэдээллийг түүнд байршуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>3.3.2. Төрийн албаны хууль, төрийн албаны стандарттай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтыг яам, агентлагын цахим хуудас болон мэдээлийн самбарт байршуулна.</p>	<p>УУХҮЯ-ны <a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a> цахим хуудсанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны тухай хууль,</li> <li>- Ашигтмалтмалынтухайхууль</li> <li>- Газрынхэвлийнтухайхууль</li> <li>- Түгээмэлтархацтайашигтмалтмалынтухайхууль,</li> <li>- Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль,</li> <li>- Газрынтосныбүтээгдэхүүнийтухайхууль</li> <li>- Газрынтоснытухайхууль</li> <li>- Чөлөөт бүсийн тухай хууль</li> <li>- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль</li> <li>- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль</li> <li>- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль</li> </ul> <p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>- Агаарын бохирдлын тухай хууль</li> <li>- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль</li> <li>- Технологи дамжуулах тухай хууль</li> <li>- Цөмийн энергийн тухай хууль</li> <li>- Тэсэрчдэлбэрэхбодис, тэсэлгээнийхэрэгслийнэргэлтэдхяналттавихтухайхууль</li> <li>- Хөгжлийнбодлоготөлөвлөлтийнтухайхууль</li> <li>- Гол, мөрнийурсацбүрэлдэхэх, уснысанбүхийгазрынхамгаалалтынбүс, ойнсанбүхийгазртарташигтмалтмалхайх, ашиглахыгхориглохтухайхууль</li> <li>- Хөрөнгөоруулалтынтухайхууль</li> <li>- Үндэснийаюулгүйбайдлынтухайхууль</li> <li>- Байгальорчныгхамгаалахтухайхууль</li> <li>- МонголУлсынЗасагзахиргаа, нутагдэвсгэрийннэгж, түүнийудирдлагынтухайхууль</li> </ul> <p>зэрэг 24 хууль, төрөөс баримтлах 9 бодлогын бичиг баримт, УИХ-ын 6 тогтоол, Засгийн газрын 17 тогтоол, Салбарын сайд, ТНБД-ын 18 тушаал, салбарын үйл ажиллагаатай холбоотой 19 дүрэм журмыг байршуулсан байна.</p> <p>Биелэлт 100 %</p>
28.		<p>3.3.3. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг яам, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд тухай бүр</p>	<p><a href="http://www.mmhi.gov.mn">www.mmhi.gov.mn</a>сайданд хүний нөөц түүнтэй холбоотой мэдээлэл болон салбар зөвлөлийн хуралдааны тойм, хуралдааны шийдвэр буюу тогтоолуудыг байршуулсан.</p> <p>Биелэлт 100 %</p>

			байршуулна.	
<b>Дөрөв. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, хуулийн хэрэгжилтийн мониторинг-үнэлгээ, хяналт шалгалт</b>				
	29.	4.1. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ мониторинг/, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж гаргаж, холбогдох этгээдэд өгөх.	4.1.1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмж өгнө.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллана. Биелэлт 100%
7	30.	4.2. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын зөрчлийг арилгуулах	4.2.1. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын зөрчлийг арилгуулах талаар журамд заасны дагуу шат дараалсан арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлнэ.	- УУХҮЯ-ны мэргэжилтэн Б.Лхамсүрэн хүүхэд асрах чөлөөний хугацаагаа дуусган ажилдаа орох хүсэлтээ 2018 оны 6 дугаар сард гаргасан боловч тухайн албан тушаал, ажлын байранд ажиллуулахад мэргэжлийн шаардлага хангахгүй үндэслэлээр нь өөр ажлын байранд буюу УУХҮЯ-аас хэрэгжүүлж буй төслийн нэгжид бичиг хэргийн ажилтаны ажил олгосон боловч Төрийн албаны зөвлөлд гомдол гаргасан. ТАЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1077 дугаар албан бичгийн дагуу ТНБД-ын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Б/129 дугаар тушаалаар Б.Бат-Оргилыг ажлаас чөлөөлж, Б.Лхамсүрэн ажилдаа орсон. - Уул уурхайн яаманд ажиллаж байгаад 2016 онд шинэчлэн байгуулагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бүтцийн өөрчлөлтөөр ажлын байр нь хадгалагдаагүй, хүүхэд асрах чөлөөтэй байсан Ж.Амаржаргалын хүүхэд асрах чөлөөний хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалыг зохих журмын дагуу төлж байсан байна. Ж.Амаржаргал ажилд орох хүсэлт гаргасан боловч түүний ажлын байр УУХҮЯ-нд хадгалагдан ирээгүй тул ажлын байранд томилох боломжгүй байгаа бөгөөд мөн ТАЗ-д өргөдөл гаргасан. ТАЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1046 дугаар Ж.Амаржаргалыг ажилд томилох тухай албан бичгийг хүлээн авсан боловч ажилд томилох, шийдвэрлэх боломжгүй байна.
	31.		4.2.2. Зөрчлийн тухай мэдээллийг ил тод мэдээллэх, зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцаж үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай гэж үзвэл салбар	1. Б.Лхамсүрэн нь УУХҮЯ-ны Түлшний бодлогын газарт мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд түүний эзэмшсэн сэтгүүлчийн мэргэжил тухайн ажлын байрны шаардлагад нийцэхгүй, түүний оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан Б.Бат-Оргил нь газрын тосны инженер, гадаадад

		зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.	магистрын зэрэг хамгаалсан зэрэг олон давуу талтай учир ажлын байрны шаардлагад илүү нийцэж байсан болно. Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр Б.Лхасүрэнд Төрийн захиргааны удирдлагын газарт хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн ажлын байранд ажиллах санал тавьсан боловч өөрөө хүлээн зөвшөөрөөгүй болно. 2. Ж.Амаржаргалын хүсэлтийн дагуу ажилд томилох боломж гарахыг хүлээж байна. ТНБД ажлын байр суларсан тохиолдолд эхний ээлжинд ажилд томилох чиглэл өгсөн байгаа. Биелэлт 100 %
<b>Тав. Салбар зөвлөлийн дотоод ажлын зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх талаар:</b>			
1	32.	5.1.1. Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулна.	2018 оны 10 дугаар сард Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитэй хамтран зохион байгуулсан "Төрийн албаны хүний нөөцийн бодлого, удирдлага" сэдэвт 3 өдрийн сургалтад хамрагдаж, сертификат авсан. Биелэлт 100%
	33.	5.1.2. Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааныг тухай бүр зохион байгуулж төлөвлөсөн асуудлыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.	Төрийн албаны салбар зөвлөл 2018 онд нийт 7 удаагийн хуралдааныг зохион байгуулсан. Хуралдааны тэмдэглэл 7, хурлын шийдвэрийн дагуу нэр дэвшүүлэх тухай 7 тогтоол гарсан байна. Биелэлт 100%
	34.	5.2.3. Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж зөвлөлийн даргаар батлуулна.	Салбар зөвлөлийн 7 удаагийн хуралдааны төлөвлөгөөг боловсруулан ТАСЗС-ийн даргаар батлуулсан. Биелэлт 100%
	35.	5.2.4. Төрийн албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлэх болзол хангасан төрийн албан хаагчдын судалгааг бэлтгэх, асуудлыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.	Монгол улсын их хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дугаар тогтоолын 4, 5 дахь заалтуудаар Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоох, цаашид 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх тул зэрэг дэвийн асуудлыг 2018 онд хэлэлцээгүй. Биелэлт 100%
	36.	5.2.5. Яам, агентлагийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоонд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах журам"-ын дагуу сонгон шалгаруулалт явуулж дүнг салбар зөвлөлийн хурлаар	2018 онд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах 6 комиссыг ТАЗСЗ-ийн тогтоолоор байгуулан ажиллаж, дараах удирдах албан тушаалд томилуулав. Үүнд: - УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар томилогдохоор нэр дэвшигчдийг удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад оруулахаар ТАЗ-д хүсэлт хүргүүлэн тогтоол шийдвэр гаргагуулав.

		<p>хэлэлцүүлж тогтоол гаргуулах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- УУХҮЯ-ны ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, ХҮБГ-ын Техник, технологийн хэлтсийн дарга, ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга, АМГТГ-ын 6 хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшигчдийг сорилын шалгалтад оролцуулах хүсэлтийг холбогдох материалын хамт ТА3-д хүргүүлж, дүгнэлт гаргуулж, тус тусын албан тушаалд томилогдсон.</li> <li>- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “УУХҮЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулатын бүтцийг батлах тухай” 370 дугаар тогтоол батлагдсантай холбоотой шинээр удирдах албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулав.</li> </ul> <p>Дараах 3 газрын даргын албан тушаалд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга</li> <li>- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li> <li>- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргад нэр дэвшигчдийн танилцуулга, бичиг баримтыг журмын дагуу бүрдүүлэн ТА3-д хүргүүлэн удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцуулан тогтоол шийдвэр гаргуулж, мөн дараах 4 хэлтсийн даргын албан тушаалд:</li> <li>- Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга,</li> <li>- Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Геологийн хэлтсийн дарга,</li> <li>- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүнд үйлдвэрийн хэлтсийн дарга</li> <li>- Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Газрын тосны хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдийг ТА3 дээр удирдах ажилтны сонгон шалгаруулалтын сорилын шалгалт, ТА3СЗ дээр ерөнхий болон ярилцлагын шалгалттуудыг зохион байгуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэлт, тогтоол гарган тус тусын нэр дэвшсэн албан тушаалд томилуулах ажлыг зохион байгуулав.</li> </ul> <p>Биелэлт 100%</p>
37.		<p>5.2.6. ТАСЗ-ийн баримт бичгийг чанартай боловсруулж , хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, Архивын нэгжийг бүрдүүлнэ.</p>	<p>ТАСЗ-ийн баримт бичгийг боловсруулж, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, ажилласан. Архивын нэгжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Биелэлт 100%</p>

ТАНИЛЦСАН:  
ТАЗСЗ-ИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
ТАЙЛАН БИЧСЭН :  
ТАЗСЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.БАЯРАА

Ш.УРАНЧИМЭГ